



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/702  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ  
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА С.ГОНЧИГНЯМ  
ТАНАА

### Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл


Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (7 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Цагаан-Уул Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ:


- Ардчилал, хүний эрх, эрх чөлөө, Монгол орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт хийх Засгийн газрын хөтөлбөрүүд, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг сум орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- Үндэсний эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялаг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт хариуцлагатай иргэний нийгмийг төлөвшүүлэхэд бидний эрхэм зорилго оршино.
- Хүний жам ёсны эрх, эрх чөлөө, төрийн хязгаарлагдмал оролцоо, төрийн нээлттэй, ил тод, иргэдэд хянагдах тогтолцоог ханган ажиллана.
- Иргэд, олон нийтийн санал, санаачилгад тулгуурлан шууд ардчиллын зарчмыг баримтална.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ТОЛИЛУУЛЖ БАЙНА.

НЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхдээ түргэн шуурхай, чанартай, намчирхаж алагчлахгүйгээр сэтгэл ханамжийн баталгаатай үйлчлэхийг зорилго болгоно.

- Төрийн бүх шатны албан хаагчдыг үүрэгжүүлж, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болно.
- Багийн засаг даргыг багийн иргэдээс ирсэн санал, үнэлэлт дүгнэлтэд үндэслэн үүрэг чиглэлээр хангаж хариуцлагын тогтоолцоог нэмэгдүүлнэ.
- Иргэддээ нээлттэй байх, иргэдийн оролцоог хангах үүднээс сумын "Орон нутгийн хөгжлийн сангийн журам", "Сумын нийтийн зар, мэдээний журам", баг бүр "Багийн Иргэдийн Нийтийн Хурлын журам"-ыг шинэчлэн баталж мөрдүүлнэ.
- ИТХ, ЗДТГ-ийн албан хаагчдыг хагас жил тутамд хөдөөгийн багт нэгдсэн байдлаар ажлын 5 хоног байрлан ажиллуулна.
- Иргэн суман дахь төрийн болон төрийн бус байгууллагуудаас төрийн үйлчилгээг авахдаа түргэн шуурхай хүнд сурталгүй үйлчлүүлэх арга хэмжээг авч ажиллана.
- Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цагийн хийдэгдэл гаргахгүй байлгах, хяналтын тогтолцоог нэвтрүүлнэ.
- Хэт намчирхах, нутгархах, ах дүүсэг хандлага бий болсноос төрийн албаны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгааг өөрчлөн шинэчлэх.
- Сумын ИТХ-ын үйл ажиллагааг сайжруулж, иргэд нийтийн хурлын үр өгөөж, чанарыг сайжруулах.
- Сумын төрийн албан хаагчдын ажил хариуцах чадвар, харилцаа хандлагыг сайжруулах, иргэнд үйлчлэх чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.



*Handwritten signature*

0000000001


- Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүх талаар бүрдүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл авах боломжоор хангаж ажиллана.
- Төр, захиргааны бүх шатны хяналтыг сайжруулж, ил тод, нээлттэй байдлыг хангаж иргэдэд нээлттэй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллана. Сумын ИТХ, ЗДТГ-ын ажил, үүрэг, үйл ажиллагааг иргэн хүн хүссэн цагтаа үзэж харах, үзэл бодлоо илэрхийлэх боломжоор бүрэн хангана.
- Орон нутагт орж буй хөрөнгө оруулалтыг иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж зарцуулалтад тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Аливаа асуудлыг аль нэг албан тушаалтан бус иргэд, иргэдийн нийтийн хурлаас голлон шийдвэрлэдэг болох, иргэдийн нийтийн хурлыг чадавхжуулах арга хэмжээг авч ажиллана.

### ХОЁР. ИРГЭДИЙН АЖЛЫН БАЙР, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын харилцааг шинэ шатанд гаргаж, иргэдийг ажлын байраар хангах, орлого нь амьдрал ахуйд нь хүрэлцдэг болох, бизнест ээлтэй орчин бүрдүүлэх, нийгмийн халамж шаардагдах иргэдийг дэмжих нь гол зорилтын нэг байна.

Ажлын байр, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр

- Иргэдийн орлогын эх үүсвэртэй болох санал санаачилгыг дэмжиж холбогдох газруудад уламжлан ажиллах.
- Төсвийн болон гаднын төсөл хөтөлбөр, сангийн тусламжтайгаар хийгдэж байгаа ажлууд тэдгээрийн санхүүжилтэд тавих иргэдийн оролцоо, хяналтыг сайжруулах талаар анхаарч ажиллана.
- Газар өмчлөлийг бүрэн шийдэж, өмчилсөн газраар барьцаалан санхүүгийн эх үүсвэртэй болох бодит боломжийг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулна.
- Суманд гарсан сул ажлын байранд эхний ээлжид орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлийг бодлогоор хангаж ажиллана.
- Ажлын байрыг нээлттэй, ил тод зарлаж ажилд авахдаа зөвхөн шалгуурын дагуу шалгаруулалтаар ажилд томилох.
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зээлийн санг нэмэгдүүлэн зээлийн хэмжээ, хугацаа, нөхцөлийг сайжруулан үргэлжлүүлэн олгоно.
- Иргэдэд зориулсан аливаа мэдээллийг хүргэх “Зар мэдээний сүлжээг” мэдээллийн бүхий л суваг ашиглан түргэн шуурхай хүргэх талаар анхааран ажил хэрэг болгон ажиллана.
- Хөдөөгийн малчдын мэдлэгийг нэмэгдүүлэхэд анхааран сургалт зохион байгуулж ерхийн аж ахуйгаа хөтөлж явуулах боломжоор хангана.



*(Handwritten signature)*


0000000000

- Сумаас гаралтай өөр улс орон, аймаг, нийслэлд ажиллаж байгаа уугуул иргэдийн мэдлэг боловсрол, арга туршлага, санал зөвлөгөөг ашиглах үүднээс нутгийн зөвлөлтэй байнга хамтран ажиллана.
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний харьяа нийгмийн ажилтны болон Багийн Засаг даргын ажлын уялдаа холбоог сайжруулж, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Улс, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр хийгдэх тендер, худалдан авах ажиллагааг иргэдийн оролцоотой ил тод, нээлттэй зохион байгуулж сум орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААН, хоршоо, бүлэг, нөхөрлөл, хувь хүмүүсийг оролцох боломжоор бүрэн хангаж орлого нэмэгдүүлэх талаар бодлогоор анхаарч ажиллана.
- Нутгийн урчуудын эвлэлийг байгуулж тэдний бүтээлийг бүс, аймаг, сумын хэмжээнд таниулан худалдаалах арга хэмжээг байнга зохион байгуулна.
- Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг нэвтрүүлж ажил олгогч болон ажил хайж буй иргэдийн хооронд зуучлах ажлыг хийнэ.

Уламжлалт мал аж ахуй, мах, сүүний чиглэлээр

Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгож, нутгийн шилмэл омгийн сүрэг, эрчимжсэн МАА хослуулан хөгжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах замаар сумын хүн амын хүнсний хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

- Бэлчээрийг хамгаалах, ашиглагдахгүй бэлчээрийг усжуулах замаар бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэх, даац хэтэрсэн бэлчээрийг өнжүүлэх, зах хязгаар нутагт тэлж эзэмших зэргээр малчдын оролцоонд тулгуурлан бэлчээрийн менежментийг сайжруулна.
- Сумын бэлчээр ашиглах журмыг багийн ИНХ-аас гарсан багийн иргэдийн шийдвэртэй уялдуулан жил бүр шинэчлэн гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Нутгийн шилмэл омгийн малыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг дэмжинэ.
- Сумын хадлан тэжээлийн нөөцийг тогтмол бүрдүүлнэ.
- Иргэдийн хадлангийн талбай хөцөөлөх, нөөц бүрдүүлэх, тэжээлийн ургамал тариалах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- Орон нутгийн иргэдэд малын хашаа барих, сэлбэн засварлахад зориулан хэрэглээний модны зөвшөөрлийг хөнгөлөлттэйгөөр шуурхай олгож ажиллана.
- Хоршоо, нөхөрлөл бүлэг багаар ажиллах малчдыг хөтөлбөрөөр дэмжиж ажиллана.
- Малын арьс шир, сүү, цагаан идээ, мах зэрэг түүхий эдийн анхан шатны боловсруулах хувийн хэвшлийн жижиг үйлдвэрүүдийг дэмжин ажиллуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах.
- Мах, махан бүтээгдэхүүн, арьс шир бүтэн болон хагас боловсруулах үйлдвэр байгуулах, малчдын гар дээрээс мах махан бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгүүлэн экспортлох боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллана. Ингэснээр малчдын орлого нэмэгдэнэ.




*Олор*

0000000007

- “Чинээлэг малчин” хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж малчдыг “Малчин бизнесмен” болгох замаар тогтмол орлоготой болгох ажлыг МАА-н татвараас ОНХС-ийн журамд нийцүүлэн зохион байгуулж ажиллана.

❖ Дэд бүтэц

- Орон нутгийн хөгжлийн сангийн журамд заасны дагуу саналыг оруулж ОНХС-ийн хөрөнгөөр зам гүүрийг шинэчлэх ажлыг зохион байгуулна.
- Гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- Мэдээлэл технологийн нэгдсэн сүлжээтэй болох.
- Шинээр баригдаж буй гудамж хорооллыг гэрэл цахилгаан, дэд бүтцээр хангах
- Улсын төсөвт тусгуулах замаар хорооллуудын дундах хатуу хучилттай замыг нэмэгдүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулан ажиллана.
- ОНХС-ийн саналд тусган шаргын голын гүүрийг шинэчлэх, засварлах, хатуу хучилттай болгох ажлыг аймаг орон нутгийн төсөвт тусгуулах замаар шийдвэрлүүлнэ.
- Цагаан-Уул сумын авто замын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж, авто замыг хүн тээвэр, аж үйлдвэрийн ачаа тээвэрлэгч, аялал жуулчлалын чиглэлээр ангилж даац маршрутыг тодорхойлох ажлыг дэс дараатай хийнэ.
- Хийгдсэн зураг төсвийн дагуу санхүүжилтийг улсын төсөв болон төсөл хөтөлбөрүүдийн оролцоотойгоор шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг хийж хэрэгжүүлнэ.
- Суманд төвлөрсөн халаалт дулаан, цэвэр бохирын сүлжээнд холбогдсон орон сууц, хаус хорооллыг бий болгох талаар шат дараалсан арга хэмжээ авч ажиллана.
- Зайлшгүй шаардлагатай гүүр сайжруулсан зам барих асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.
- Сумын суурины ундны усны талаар цогц бодлого дэвшүүлэн ажиллана.
- Сумын суурины дулаан хангамжийг сайжруулах, гудамж хорооллыг дулааны шугамд холбох ажлын зураг төсвийг боловсруулах ажлыг хийж улсын төсөвт суулгах саналыг холбогдох байгууллагад уламжлан ажиллана.
- Дэд бүтцийн салбарыг хөгжүүлж эдийн засгийг сайжруулах, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Сумын төвийн тохижилт үйлчилгээний компанийг үйл ажиллагааг сайжруулж, ил задгай хог хаягдал хаяхгүй, орчны бохирдлыг арилгах, гудамж хороололд хогийн сав байршуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн төслийг боловсруулан ажлын байр бий болгон ажиллана.
- Хот хоорондын болон сумд, аймгийн төвийн доторх нийтийн тээврийн үйлчилгээг тухайн салбарт ажиллагсадтай хамтран журамлаж, аюулгүй ажиллагааг хангуулах арга хэмжээ авна.
- Оршин суугчдын оролцоотойгоор тухайн гудамж хорооллоо шинэчлэх төслийг иргэдийн оролцоотой шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллана.



*Handwritten signature in blue ink.*

0000000004


- Гудамж хороолол, хашаа, амины орон сууцтай болоход сумын эрх хэмжээний хүрээнд бодлого гарган дэмжиж ажиллана.
- Орон нутгийн барилгын компанийг бодлогоор дэмжин байгуулж суманд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд давуу эрхтэйгээр оролцуулна. Ингэснээр хөрөнгө оруулалтын бүтээмж чанар нэмэгдэнэ.
- Үерийн ус зайлуулах далан, суваг, шуудууг цогцоор нь хийж гүйцэтгэнэ.

#### ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хөнгөн шуурхай, чанартай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Ахмадуудад үзүүлж байгаа нөхөн сэргээх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлчилгээний чанарыг сайжруулна.
- Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд анхаарч хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэж, өвдсөний дараа бус өвдөхөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.
- Архигүй сум, баг, байгууллага, хамт олон, гэр бүл, гудамж хороолол болоход хүн бүрийг уриалж системтэйгээр архинаас татгалзах арга хэмжээг зохион байгуулна.
- Эрүүл мэндийн байгууллагуудыг стандартад заагдсан орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжөөр хангуулах.
- Үйлчлүүлэгч төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр зорилтот бүлгийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амд илүү анхаарсан “Үйлчлүүлэгч төвтэй” тогтолцоог бүрдүүлнэ.
- Цагаан идээ, малын мах,сүү, яс, цус, ургамал эрдсийн гаралтай түүхий эдээс эмчилгээний болон эрүүл мэндийг сайжруулах нэмэлт бүтээгдэхүүнийг өрхийн үйлдвэрлэлийн хэмжээнд боловсруулах, ашиглах, хэрэглэх сургалт явуулна.
- Сум дундын эмнэлгийг мэс засал, дотор, мэдрэл, шүд эрүү нүүр, хүүхэд, төрөх эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчээр хангах тэднийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар анхаарч ажиллана.
- Эх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж ,үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- Хөдөө алслагдсан нутгийн иргэдэд зориулсан нүүдлийн амбулаторийн үйлчилгээ бий болгож улиралд нэг удаа эрүүл мэндийн иргэнд хүрч үйлчлэх үйлчилгээг бий болгоно.
- Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг сард нэг удаа явуулж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмолжуулан ажиллана.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас олгогдох хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран бодлого боловсруулан ажиллана.

#### ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- Ерөнхий боловсролын сургуультай хамтран “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн агуулгыг орон нутгийн онцлогтой уялдуулан агуулгын шинэчлэл хийж эх орон, нутаг



*[Handwritten signature]*


0000000005

ус, ард иргэдээ хайрлан хамгаалах зан үйлийг төлөвшүүлэн эх оронч сэтгэлгээтэй, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх ажлыг хийж хэрэгжүүлэх

- Бага дунд ангийн сурагчдын чөлөөт цагаа зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх орчин нөхцөлийг анхаарч хичээллэх секц, дугуйланг нэмэгдүүлнэ.
- Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдэд нутаг ус, байгаль орчноо хамгаалах, бүтээж бий болгосон зүйлээ хайрлан хамгаалах дадал хэвшлийг олгоход илүү анхаарсан сургалт, хүмүүжлийн иж бүрэн арга хэмжээ авна
- Цэцэрлэг, гэр цэцэрлэгийг шаардлагатай багт, олон айл өрхийн дунд байгуулах ажлыг зохион байгуулж, сургуулийн өмнөх боловсролын хамрах сургалтыг нэмэгдүүлнэ.
- Хүүхдийн сурах орчин, нэг ангид байх хүүхдийн тоог стандартад нийцүүлэн шинээр баригдах хороолол, төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлчилгээний газруудыг оруулж байх.
- Цэцэрлэг, сургуулийн удирдлага болон эцэг эхчүүд, зөвлөлийн хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтран ажиллах дүрэм, арга зүйн зөвлөмжтэй болгоно.
- Мэдээллийн технологийг сургалтын орчинд өргөнөөр ашиглах, сурах бичиг, видео хичээл, танин мэдэхүйн цахим хуудас нээж ажиллуулна.
- Сумын соёлын төвийн орон тоо, үйл ажиллагаа бүтцийг хянаж, Номын сангийн үйлчилгээг сайжруулах, Интернет мэдээллийн төвүүдийг байгуулах
- Соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлан түгээх үндэсний чадавхыг нэмэгдүүлнэ.
- Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбоно.
- Соёлын төвийг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн иргэдэд үзүүлэх үйлчилгээг шинэ түвшинд хүргэнэ

#### **ТАВ. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

- Орон нутаг дахь иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргана.
- Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, иргэд амрах, алжаал тайлах, шинэ орчин, байгууламжуудыг төлөвлөж шийдвэрлэнэ.
- Одоогийн баяр наадмын талбайг хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх парк болгон тохижуулна.
- Шинээр баяр наадмын талбайг барьж байгуулна.
- “Хашаандаа сайхан амьдаръя” төслийг сумандаа хэрэгжүүлэн ажиллаж айл өрхийн болон нийтийн бие засах газруудыг шинэчлэн байгальд ээлтэй био 00-оор солих ажлыг шат дараатай хийж хэрэгжүүлнэ.
- Иргэдийн тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргийг бууруулах зорилгоор гудамж талбайн гэрэлтүүлэгт анхаарч, хяналтын камерыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах ажлыг шат дараалан шийдвэрлэнэ.



*[Handwritten signature]*

0000000006




- Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, “хөршийн хамгаалалт” иргэдэд суурилсан амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ.
- Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа явуулахад бүхий л талаар дэмжин ажиллаж “Эмэгтэйчүүдийн ордон” барих ажлыг хийнэ.
- Архи, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг чангатгаж, тэдгээрийн хэрэглээг үл тэвчих орчин ба соёлыг төлөвшүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулах, тэднийг нийгмийн харилцаанд татан оролцуулах ажлыг хийж оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нь нэмэгдүүлнэ.

#### Хил хамгаалах

- Хил хамгаалах байгууллагатай гэрээ хийж хамтарч ажиллах ба тэдэнд тодорхой тусламж дэмжлэг үзүүлнэ.
- Хилийн застав, тэдний байрладаг багийн удирдлага хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана.
- Хилийн застав, цагдаагийн хэсгийн алба хаагчдын гэр бүлийг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулан ажиллах.

#### Байгаль орчин.

- Байгаль орчныг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаанд иргэдийн санал санаачилгыг тусгаж бодлогоор дэмжиж ажиллана.
- Иргэний байгалиа хамгаалах, мод тарих, нөхөн сэргээх гэх мэт өөрийн санал санаачилгаар хийсэн ажлыг бодлогоор дэмжиж урамшууллын асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- Усны зүй зохистой хэрэглээг бий болгох
- Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль дүрмийг иргэдэд сурталчлах, байгаль орчны талаарх хууль тогтоомжийг зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах төрийн нэрийн өмнөөс ажиллаж буй БОУБайцаагч, байгаль хамгаалагч нарын ажлын арга барилыг шинэ түвшинд хүргэнэ.
- Байгаль орчин, хүний амьдрах орчинд сөрөг нөлөөтэй болон гол усны ай савд хор хөнөөлтэй аливаа уул уурхай, хүнд үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжихгүй, хэрэгжүүлэхгүй.
- Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын цогцолбор, жуулчны үйлчилгээний газруудыг Оргомчийн булан, Тунамал нуур, Гандан нуур, Сангийн далай зэрэг газрыг Монголын аялал жуулчлалын үндсэн бүсүүдтэй холбосон жуулчид аялах оновчтой маршрут, сүлжээг бий болгох, холбогдох дэд бүтцийг сайжруулж, байгалийн болон адал явдалт, тусгай сонирхлын аяллыг өргөжүүлнэ.
- Идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулан ажиллуулж байгаль хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх



172000001

*[Handwritten signature]*

0000000007